



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-13</i>
<hr/>	
<i>1. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>5-13</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 05 дугаар сарын 29-ний өдөр
/Даваа гараг гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 32 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал, Ц.Даваасүрэн, Ч.Ундрам, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: С.Чинзориг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Цэрэнпунцаг, Б.Энхбаяр.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга Ч.Энх-Амгалан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга О.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга Л.Балчинлувсан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Л.Лувсан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт П.Сарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Батлут, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах санал.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1.24 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих” гэж нэмэх, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Санхүүжилтэд “75.17 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд олон ба гурван талт зөвшилцөл, түншлэл, хяналтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэн хэвшүүлнэ.” гэсэн 7.6 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1 дэх заалтын Төсөл, арга хэмжээнд “Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг Цэцэг сумыг холбох авто зам барих “32.4 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “Ажлын гүйцэтгэл” гэж, Санхүүжилтэд “29 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ж.Бат-Эрдэнэ: 1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “үндэслэнн боловсрууллаа.”

“үндэслэлээ” гэж, “төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа” гэснийг “төлөвлөгөө нь” гэж, “үндэслэн” гэснийг “үндэслэсэн бөгөөд” гэж “тодорхойлоо” гэснийг “тодорхойлно” гэж, мөн тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Бодлогын үндэслэл” хэсгийн Алсын Хараа /АХ/, 2.3.2.16 дахь дэд заалтын “3.2.14” гэснийг “6.4.22” гэж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /МУХТЖҮЧ/-ийн 2.1.3 дахь заалтын “4.2.2” гэснийг “4.4.3” гэж, мөн 3.1.4.1-3.1.4.5, 3.1.4.7, 3.1.4.8, 3.1.5.1 дэх дэд заалтын “2.1.9” гэснийг “2.1.12” гэж, мөн 4.2.1.1 дэх дэд заалтын “3.6.4” гэснийг “4.2.10” гэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-ийн 6.2.3 дахь заалтын “4.3.9” гэснийг “3.5.7” гэж, мөн тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын “бүсүүд” гэснийг “бүсүүдийн” гэж, 3.2 дахь заалтын Хэмжих нэгжийн “Хүн” гэснийг “Хувь” гэж, 3.3.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлтийн “хамралт” гэснийг “хамрагдалт” гэж, 3.3.3 дахь дэд заалтын Зорилтот үр дүнгийн “нэмэгдэнэ” гэснийг “нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлтийн “насныхны” гэснийг “насны” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 40 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр,
Даваа Төрийн ордон “Их эзэн Чингис
хаан” танхим 11 цаг 32 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн өвчтэй. Баагаагийн Баттөмөр ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Жамбалын Ганбаатар гишүүн ирсэн. Наянтайн Ганибал орон нутагт ажилтай байна. Хассуурийн Ганхуяг ирсэн. Цэрэнпилийн Даваасүрэн орон нутагт ажилтай. Тогмидын Доржханд ирсэн. Болдын Жавхлан ирсэн. Дамдинсүрэнгийн Өнөрболор ирсэн. Чинбатын Ундрам орон нутагт ажилтай. Оюунчимэг гишүүн ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Баттөмөрийн Энхбаяр өвчтэй. Төмөртоогогийн Энхтүвшин орон нутгийн ажилтай байна.

Ингээд ирц 55 хувьтай. Байнгын хорооны гишүүдийн олонхын олонх хүрэлцэн ирсэн. Байнгын хорооны ирц 55,6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2023 оны 04 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал.

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Баттөмөр даргад микрофон өгье. Ажлын хэсгийг танилцуулаадахъя, ажлын хэсэг хаана байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Балчинлүвсан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Одгэрэлийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, П.Сарангэрэл ЗГХЭГ-ын референт.

Ингээд Баагаагийн Баттөмөр гишүүнд микрофон өгье.

Б.Баттөмөр: Монгол Улсын Засгийн газар Эдийн засгийн хөгжлийн яамнаас Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг УИХ-д өргөн барьсан хуулийн хугацаандаа. Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг ажиллаад зарчмын зөрөөтэй 16 саналыг гаргаад Эдийн засгийн байнгын хорооны анхны хэлэлцүүлгийг хийсэн. Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан Эдийн засгийн байнгын хороон дээр. Энэ дээр бол ажлын хэсэг 16 санал гаргасан.

Дээрээс нь Улсын Их Хурлын гишүүд 12 санал гаргасан. Ингээд 28 санал байгаа. Дахиад дэмжигдээгүй 1 санал байгаа. Найруулгын шинж чанартай 1 санал байгаа. Ингээд нийт 30 санал гарсан. 30 саналаар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээд 26 санал дээр нь санал хураалт явуулаад, 4 санал дээр нь гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын даргаас чиглэл болгож өгсөн. Тийм. Одоо энэ 4 санал дээрээ ярих, өөр бусад асуудлууд байвал үүнийг өнөөдрийн хурлаар хэлэлцэх ийм асуудал байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн санал, танилцуулгаас асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Пүрэвдорж гишүүн. Батлут гишүүн, Баярсайхан гишүүн, Баярсайхан гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Монгол Улс парламентын засаглалтай орон. Гэтэл өнөөдөр парламентын толгой дээр Засгийн газар гарч суусан. Өөрөөр хэлбэл Засгийн газраас оруулж ирж байгаа 2024 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг тэр чигээр нь явуулах ийм л зүйлийг өнөөдөр энэ Эдийн засгийн байнгын хороо хийж байна. Ажлын хэсэг дээрээ нэг хэдэн санал гаргасан юм шиг байгаа юм. Түүнийгээ Их Хурлын гишүүдээс нууж

байгаад гаргасан. Ер нь Их Хурлын гишүүн Байнгын хороон дээр орж саналаа гаргах ёстой. Үүний дагуу хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг баруун аймгийн төв замыг Хөшөөтийн замтай холбох замаар Ховд аймгийн сумуудын олон сумуудыг холбох ийм дөт замаар явуулах ийм боломжийг гаргасан. Энэ заалтыг гаргасан. Харамсалтай нь Засгийн газрын гишүүдийн саналаар ер нь энэ Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг ер нь авахгүй гэдэг ийм байр суурийг гаргаж байх шиг байна.

2022 оны 8 сарын 29-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд өөрсдийнхөө эрх ашиг, ямбын төлөө нэгхэн өдрийн дотор өөрчлөлт хийж, давхар дээл авцаасан. Давхар дээлээр 20 гаруй сайд Их Хурлаас ажиллаж байгаа. Тэд нар нь тэгээд нэг 3, 3 Их Хурлын гишүүнийг хариуцаж авдаг юм шиг байгаа юм. Тэгээд Засгийн газрын бүх юмыг энд явуулдаг. Их Хурлын гишүүдээс ямарваа нэгэн санал авдаггүй, толгой дээр гарчихсан, тэгээд эд нарын эрх ямба нь багадаад өөрсдөө Их Хуралд суухгүй, чуулганд суухгүй, дандаа тасална. Тэр тасалснаас болоод ирц хүрэхгүй, ирц хүрэхгүйгээс болоод яаж байна вэ гэхээр хууль муу гарч байгаа. Муу гарч байгаа үндсэн шалтгаан нь энэ Их Хурлын гишүүний тоо бага байна гэдэг худлаа юм яриад өөрсдөө ингээд энэ гишүүдийн тоог нэмэх тухай асуудлыг ингээд яриад явж байна л даа.

Тэгээд Засгийн газар нь толгой дээр гарчихсан. Тэгээд парламентын засаглалтай оронд ерөөсөө ингээд парламентынхаа гишүүдийг нэг 2, 3-аар нь дуугүй байж бай гэж байгаад асуудлаа шийдүүлдэг ийм л болж байна шүү дээ. Үгүй ээ, тэгээд саналаа хураалгаад л унагаавал унагаана л биз дээ. Тэр асуудал биш шүү дээ. Тэгээд бүгдийг нь хасна, ингэнэ, тэгнэ гэдэг байдлаар асуудалд хандаж болохгүй. Мэдээж эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгааг би мэдэж байна. Тэгэхдээ зарим нэгэн зүйлийг урагшлуулж байх ёстой шүү дээ. Өнөөдөр

ингээд улсын хэмжээний зам Дарханы замыг л 200км-ийг арай гэж тавилаа шүү дээ. 6 жилийн дараа. Тэгээд энэ Монгол Улсын хөгжилд чинь хамгийн гол хэрэгтэй зүйл нь энэ дэд бүтцийн хөгжлийн асуудал шүү дээ. Энэ асуудал дээр ерөөсөө ингээд яахгүй. Одоо бол нэг над руу хариулт хэлнэ л дээ.

Орон нутгийн шинж чанартай замын хөрөнгө оруулалтыг тавихгүй, ерөнхий юугаар нэг хөгжинө гэж ярих л байх. Би хариултыг нь мэдэж л байна. Энэ байдал чинь юу руу түлхэх вэ гэх дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь асуудал руу орно шүү. Ингээд толгой дээр гарч суучаад л ер нь ингээд Засгийн газрын гишүүд нь дахиж Их Хурлынхаа гишүүдийн тоог нэмж байгаад, чуулганыхаа хуралдаанд суухгүй гэдэг ийм зүйл чинь өнөөдрийн энэ байдлаар илэрч байна шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн ээ, энэ таны орж ирсэн санал чинь одоо хэлэлцэгдэнэ шүү дээ. Дахиж хэлэлцэгдэх юм. Түүнээс биш хаасан асуудал бол ерөөсөө байхгүй. Тийм, хаасан асуудал нь байхгүй. Тийм.

Асуулт дээр Хүрэлбаатар гишүүнийг нэмчих. Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Эдийн засгийн байнгын хороон дээр урьдын хуралдаан дээр миний нэг гаргасан саналыг дэмжсэн юм байгаа юм. Тэгээд чуулганы хуралдаан дээр очоод гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн ажил байгаа. Шар хөтлийн зам гээд. Энэ Шар хөтлийн замын ажил бол үндсэндээ Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд орчихсон зайлигүй хийгдэх ёстой ажил гэж үзэж байгаа. 5, 6 аймгийн бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн нэлээн томоохон ач холбогдолтой ийм зам. Зураг төсвүүд нь бүгд бэлэн болчихсон. Ийм ажил байгаа юм. Тэгээд энэ ажлыг бас оруулаад явах тал дээр бас анхаарлаа хандуулж ажиллаж байна. Тэгээд би холбогдох хүмүүсээс нэг асуулт асууя.

Энэ санхүүжилттэй холбоотой асуудал энэ бол ЗТХЯ, Сангийн яам, Эдийн засгийн яамныхан бүгд мэдэж байгаа байх. Европын сэргээн босголтын банкныхантай ер нь ярилцаад нэг тийм зарчмын хувьд дэмжчихсэн байгаад байгаа юм. Тэгээд эндээс санхүүжүүлэх боломж бололцоо нь яг бодитой юм уу. Миний хувьд энэ 25 он хүртэл хөгжүүлэх Монгол Улсын хөгжүүлэх үндсэн чиглэлд орчихсон асуудал учраас ингээд энэ жилээсээ авхуулаад хөрөнгө оруулалт нь хийгдээд, тэр зээл тусламждаа хамрагдаад явах боломж бололцоо байгаа болов уу гэж санаж энэ асуудлыг оруулж ирж байгаа. Эхлээд явна, 25 ондоо дуусах байх. Улсын төсвөөс нэг их ачаалал авахгүйгээр ингээд явчих юм байна гээд.

Тэгээд энэ дээр нэг надад бодитой нэг хариулт өгөөч. Европын сэргээн босголтын банкныхан яг энэ салбарын яамнууд руу яг ямар чиглэл ярьж байгаа юм. Энэ замын асуудал ер нь хийгдэхэд ямар үр нөлөөтэй гэж үзэж байгаа юм? Ер нь барих шаардлага байгаа эсэх, цаашилаад яах юм бэ? Барих юм уу, үгүй юү, эсвэл гэдэг дээр надад нэг бүр тодорхой хариулт өгчхөөч.

Ингээд саяын энд ярьж байгаагаар энэ саналуудыг бүгдийг нь буцаад татах гэж байх шиг байна л даа. Үгүй ээ, уул нь ингээд хөрөнгө оруулалт хийх гэж байгаа бол аль ашигтай, олон нийтэд хүртээмжтэй, дэд бүтэцтэй холбоотой гээд нэг томоохон зүйлүүд рүү иргэдэд хүртээмжтэй байх энэ ажлууд руугаа харсан хөрөнгө оруулалтуудаа бас бодож төлөвлөөд, эхний ээлжид тавиад эрэмбэ дараа нь оруулаад явах ёстой болов уу л гэж бодох юм. Тэгээд энэ дээр нэг тиймэрхүү шийдлүүд гарахгүй байгаад харамсаж байна.

Манай Орхон аймаг, Эрдэнэт хоттой холбоотой асуудал биш энэ бүс нутгийн хэмжээнд хамааралтай зам гэдгийг би ахин давтан хэлмээр байна. Тэгээд нэг их олон ч ажил тусгадаггүй юм

даа, бидний хувьд. Орхон аймаг дээр гэхэд хөрөнгө оруулалт цөөхөн л байгаа юм. Бусад аймагтай харьцуулахад. Тэгээд ганц нэг I боломжийн ажлыг бүс нутгийн хэмжээний эдийн засгийн ач холбогдолтой ажлыг оруулах гэхээр ингээд больё, татъя гэдэг яриа үүсээд байгаа нь яг үнэндээ болохгүй байна. Болохгүй байгаа зүйлийг хэлэхээс өөр арга байхгүй. Бид иргэдэд хүртээмжтэй эдийн засгийн өгөөжөө маш хурдан өгөх тийм төсөл учраас л хэрэгжүүлж гэж бодож байгаа шүү дээ. Зорьж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр нэг холбогдох яамнууд юу гэж бодож байгаа юм, хариулаадхаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд маань татна, болино гэсэн асуудлуудыг түрүүлээд бас ярьж болохгүй. Одоо бид нар чинь санал хураалт явагдана шүү дээ. Тэгээд санал хураалтаараа асуудал ишийдээд явчихна.

Хэн хариулах вэ? Зам, тээврийн хөгжлийн сайд хариулъя. Бямбацогт сайдад, гишүүнд.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Энэ Батлут гишүүний оруулж ирж байгаа энэ санал бас сая ярьж байгаа зүйл үндэслэлтэй юм. Өнөөдөр хойд зүгийн аймгууд Дарханаар дамжаад, Хөтөл, Эрдэнэт гээд үндсэндээ Булган, Хөвсгөл аймгийнхан ингэж нэлээн тойруу замаар явж байгаа, тойруу. Дарханы чиглэлийн зам маань бас нэлээн өндөр ачаалалтай зам.

1 дүгээрт нь, энэ оруулж ирсэн саналын дагуу Сэлэнгэ аймгийн Орхон сумын Төв аймгийн Жаргалантын уулзвараас Орхон сум хүртэл энэ 100 км замыг барьчих юм бол энэ Дархан, Алтанбулаг чиглэлийн замын ачаалал 1 дүгээрт нэлээн их буурна.

2 дугаарт нь, Хөтөл, Эрдэнэт, Булган, Хөвсгөл аймгийн иргэд бас илүү богино хугацаанд, илүү бага зардлаар зорчих бололцоо боломжтой болох юм.

Ийм бас ТЭЗҮ судалгаа хийгдсэн. Тийм учраас энэ замыг бол манай яамны хувьд бас барих нь зүйтэй гэж үзэж байгаа. Санхүүжилтийн хувьд ч гэсэн бас Европын сэргээн босголтын банк бас урьдчилсан судалгаа хийгээд бас барих бололцоотой санхүүжилт бололцоотой гэсэн ийм бас саналыг хэлж байгаа. Тийм болохоор уул нь бас энэ барьчихвал уул нь, зөвхөн Эрдэнэт юм уу ганцхан аймгийн асуудал биш юм. Цаад талд нь сая хэллээ. Тийм ээ, Хөтөлийн, Сэлэнгэ аймгийнхны, цаашилаад Булган аймаг, Хөвсгөл аймаг гээд иргэд их богинохон хугацаанд зорчих ийм асуудал байгаа юм.

Тэр сая бас Пүрэвдорж гишүүн жсоохон бухимдаад гараад явчих шиг боллоо. Энэ бас Цэцэг сумыг холбох гээд тийм үү, хэвтээ тэнхлэгийн баруун босоо хэвтээ юу замаас холбох гээд. Үүний цаад талд нь бас бүс нутгийн боомт чиглэсэн экспортын ач холбогдолтой, боомт руу чиглэсэн. Үндсэндээ боомт руу чиглэсэн зам холбогдоогүй байгаа. Нэг хориодхон километр замаар холбогдоогүй, үүнийг холбочих юм бол үндсэндээ боомт руу гарах гарц маань бас нэмэгдэх юм.

Мөн баруун 3 аймгийн шахмал түлшний хэрэгцээг хангах Хөшөөтийн уурхай дээр шахмал түлшний үйлдвэр баригдаж байгаа. Энэ шахмал түлшийг бас баруун 3 аймгийн агаар орчны бохирдлыг бууруулахад энэ зам баригдчихвал бас энэ зам дээгүүр шахмал түлшийг тээвэрлэнэ. Шахмал түлш чинь өөрөө бас хагардаг, бутардаг ийм бас эмзэг бүтээгдэхүүн. Тийм болохоор бас засмал замаар тээвэрлэхгүй шороон замаар тээвэрлэх юм бол эргээд нөгөө энэ баруун 3 аймгийн бас агаар орчны бохирдлыг бууруулахад бас асуудалтай. Тэгээд ийм уул нь 2 гуравхан төсөл байх шиг байна шүү дээ, тийм ээ. Уул нь бас дэмжчих юм сан л гэсэн саналтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярсайхан гишүүн. Баярсайхан гишүүний микрофоныг нээе.

Б.Баярсайхан: Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Засгийн газраас шинэ сэргэлтийн бодлого, боомтын сэргэлт дээр маш их ач холбогдол өгч байна. Завхан аймгийн Арц суурь боомт бол нэгэн үед Завханы иргэд махаа борлуулаад, оронд нь бензин, хүнсний бүтээгдэхүүнээ авдаг байсан ийм боомт. Одоо ажиллаж байгаа хэдий ч бас иргэдийн хүсэж байгаа хэмжээнд энэ боомт ажиллаж чадахгүй байгаа.

Миний бие Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоноос хойш Арц суурь боомтоос Нөмрөг сум хүртэлх 167 км авто замын ТЭЗҮ-г санал өгч улсын төсвийн хөрөнгөөр зургийг нь хийлгэсэн байж байгаа. Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөнд шинэ сэргэлтийн бодлого, боомтын сэргэлт гэхээд тэгээд энэ 167 км замыг эхлүүлэх ажлыг хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж болоогүй юм уу? Тэгээд би үүнийг тусгуулах саналтай байна. Би дөнгөж сая Завхан аймагт ажиллахдаа Тувагийн талтай уулзаж ирсэн. Өнөөдөр яг Порше Хандгайт боомт шиг Улаангомд энэ Тувачууд ирж эдийн засгийн хөгжилд өнөөдөр эрс ийм эерэг үр дүн гаргаж байгаа ийм үед ганцхан Завхан аймаг биш Хөвсгөл, Архангай гээд Арц суурь боомтоос Цагаан боомт руу холбогдож байгаа энэ замыг боомтыг сэргээх нь чухал аа. Монголын тал энэ 167 км авто замаа барьчих юм бол тэр бензин оруулж ирэх юм уу энэ бүхий л талын харилцаа бол ингээд ОХУ руу сэргэнэ гэдгийг Тувагийн УИХ, Засгийн газрын сайд нар ингээд хэлж байгаа. Тийм учраас би энэ хэлж байгаа үгээ протоколд тэмдэглүүлээд, зураг төсөв ТЭЗҮ нь хийгдчихсэн байгаа 167 км замыг эхлүүлж өгөөч гэдэг хүсэлтийг Бямбацогт сайд танд бас би тавьж байна.

2 дугаарт, манайх АХБ-ны хэлэлцээр нэв 3 гээд байдаг байх. Хэлэлцээр дээр 198 км зам Улиастайгаас Алтай хүртэл тавигдах ёстой. Энэ 24 оны хөгжлийн төлөвлөгөө дээр 42 гээд ороод ирчихсэн байгаа. Үүнийг би

тайлбарлаж байгааг нь ойлгож байна. Энэ онд хийгдэх 42 км зам гээд байна. Гэхдээ өмнөх Их Хурлын чуулган дээр ЗТХЯ-наас хариулт өгөхдөө дараагийн 4 дэх ээлжийн төсөл дээр үлдсэн мөнгө гээд, энэ жонхуу болно. Хэзээ 4 дэх ээлж нь байх юм.

2 дугаарт, би нэг юм яах вэ баттай биш байж магадгүй, тэгэхдээ би энд бүр албан ёсоор асуучихъя. Сангийн яамнаас энэ АХБ банк руу 4 дэх ээлжийг зам биш байлгана, өөр төсөл байлгая гэсэн санал явсан гэж энэ үнэн үү? Энэ дээр бас албан ёсны хариулт өгөөч.

Тэгээд бид нар бол улсын төсвийн хөрөнгөөр биш тэртээ тэргүй АХБ-ны төсөв хөрөнгөөр 198 км зам гээд л тавигдчихсан л байгаа бол үүнийгээ бид нар хийлгэмээр байна. Говь-Алтайгаас сонгогдсон гишүүд, Завханаас сонгогдсон гишүүд хоорондоо яриад энэ чинь бүтэн 2 жил ярьж байгаа ажил. Энэ зам дээр 18 км замын санхүүжилт дутуу байгаа. Алтайгаас эхлэх юм уу Улиастайгаас эхлэх юм уу гэж байтал хаанаас эхлэх нь мэдэгдэхгүй ингээд 42 км зам гээд ингээд тавигдчихсан байгаа. Энэ яаж яваад 42 юм бэ? Яг 198-аас 42 юм уу? Тэгвэл бататгаад өнөөдөр энэ Байнгын хорооны хурал дээр сонсчихмоор байна.

Дараа нь А4 биш ээ, 4 дүгээр ээлжийн эд нар гэх юм бол АХБ-ны 4 дэх ээлжийг хүлээх юм бол бид нар үнэхээр бүтэхгүй ээ. Тийм учраас энэ 2 зам дээр яг 24 онд яг юу хийгдэх юм? Энэ дээр тодорхой хариулт авъя. Ер нь Завхан аймаг хөгжлийн хувьд асар дорой, бараг 21 аймгийнхаа 21-д явж байгаа, хамгийн сүүлд авто замтай холбогдсон ийм аймаг байгаа шүү дээ. Бусад замууд нутгийн зам гээд сумаа нийслэлтэй холбоод байхад, Завхан аймаг өнөөдөр ийм ... /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Бямбацогт гишүүн, Бямбацогт сайд микрофоныг нээе.

С.Бямбацогт: Энэ нөгөө Говь-Алтай, Завхан аймаг чиглэлд, дээрээс нь Ховд Улаангом чиглэлд АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр замууд барих ийм төслүүд явж байгаа. Улаангом, Ховдын чиглэлийн замыг холбосноороо ямар ач холбогдолтой байгаа юм бэ гэхээр үндсэндээ ОХУ-тай 2 дахь том гарцаар Орос, Хятадыг холбосон 2 дахь том коридор бий болох юм. Өөрөөр хэлэх юм бол Улаангомыг Ховдтой холбочих юм бол Тувагаас Ховдоор дамжаад баруун Шинжийн хойгуур Хятад улс руу гарах 2 дахь том коридор бий болох юм. Одоо Монгол Улс чинь үндсэндээ 3 дахь том коридор гэсэн үг.

Алтанбулаг, Улаанбаатар, Замын-Үүд гээд 1 коридортой.

Нөгөөдөх нь Баян-Өлгий, Цагааннуур, Ховд, Ярант гэсэн 1 коридор байж байгаа.

3 дахь коридор нь бол үндсэндээ энэ Увс, Ховдыг холбочихвол 3 дахь коридор бий болох юм. Ийм учраас төслийн хувьд 1 дүгээр зэргийн ач холбогдолтой гэж эрэмбэлэгдсэн юм байна лээ.

Дараачийн ээлжид энэ төслийн бас нэг багц хэсэг нь бол Алтай, Улиастай чиглэлийн зам 198 км-ийн зам байгаа. Үүний бас нөгөө АХБ-аас санхүүжилт нь хүрэхгүй байгаа учраас 42 км-ийг эхний ээлжид эхлүүлж гэж байгаа. Ер нь та бас мэднэ. Монгол төрийн бодлого залгамж чанартай, төсөв дээр нэг эхэлсэн ажлыг бид нар дуусгуулахын төлөө л явдаг. Тийм болохоор нэгэнт эхлүүлчихье, эхэлсэн заавал дуусаж л таарна. Ямар нэгэн байдлаар юу гэдэг юм АХБ-ны санхүүжилтийг өөр тийш нь татуулах зүйл байхгүй. Энэ замыг дуусгавал энд эхний ээлжид энэ зам дуусаж байж харин цаана нь эх үүсвэр үлдэх юм бол бусад төсөл рүү оруулах ийм зарчмыг барьж явна. Тийм болохоор та энэ дээр бас санаа зовохгүй байж болох байх гэж бас хэлье.

2 дугаарт нь, боомтын сэргэлтийн хүрээнд бас тэр Арц суурь, Нөмрөг чиглэлийн замыг бас анхаарах ёстой, таны хэлж байгаа зөв. Үүнийг бас боломж байдаг бол тусгачихъя 24 оны төлөвлөгөөнд. Тэгээд мэдээж төсөв, санхүү, эдийн засгийнхаа нөхцөл байдлаа харж байгаад аль болох хэрэгжүүлэх, ер нь боомтын чиглэлд харьцангуй одоо юу гэдэг юм Би Өү Ти тийм концесс нөхцөлөөр барих, ашиглах, шилжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншилэлээр бол маш олон замууд баригдаж байгаа, цаашидаа ч баригдана. Энэ хүрээндээ бас барьчих хүмүүс байх юм бас бололцоотой. Өөрөөр хэлэх юм бол санхүүжилтийн бүхий л эх үүсвэрийг бариад Монгол Улсын Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогод тусгачихсан гол зорилго бол, зорилт бол энэ боомтын сэргэлт байгаа. Энэ хүрээндээ бас энэ ажлыг төлөвлөгөөнд тусгачихвал бас аль болох эх үүсвэр болоод хэрэгжүүлэхийн төлөө бас манай яам анхаарч ажиллана гэдгийг танд хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Баярсайхан гишүүн тодруулах уу? Баярсайхан гишүүний микрофоныг нээе.

Б.Баярсайхан: Бямбацогт сайд аа, баярлалаа. Тэгвэл 198-аас 42-ыг нь энэ жил хийх юм бол үлдсэн 156 км авто замынх нь санхүүжилт нь АХБ дээрээ байж байна гэж 1 дүгээрт, ойлгож болж байна уу?

2 дугаарт, энэ 42км зам чинь манай аймгаас эхлээд 42км явах гээд байгаа юм уу? Говь-Алтайгаасаа эхлээд 42км явах гээд байгаа юм уу. Уул нь 18км-ийн л санхүүжилт дутуу байгаа. Бараг л энэ зам бүрэн хийгдэх боломжтой. Тэгэхээр уул нь үүнийгээ ингээд хийчихмээр байна.

Төсөв нь яг байх уу гэдэг асуудал байна.

2 дугаарт, тэр мега төсөл, эдийн засгийг хөгжүүлэх энэ болгоныгоо ойлгож

байгаа, ойлгосоор явж байгаа энэ 30 жилийн хугацаанд Завхан аймаг л хөгжсөөгүй ийм гишүүн түүхтэй үлдсэн нь үнэн. Тэгэхээр тэнд 75 мянган хүн амьдарч байгаа бол бид нар үүнийгээ аймаг гэж бодож байгаа юм бол бид нар бас замаа тавьчихмаар л байна.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 номер. Батболд ТНБД. Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД.

С.Батболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. АХБ-тай хийсэн хэлэлцээр дээр Алтай, Улиастай гээд орчихсон явж байгаа. Яг энэ 42-ыг аль талаасаа эхлэх тухай одоогоор тодорхой дурдаагүй байгаа, энэ дээр. Энэ хэлэлцээр өөрөө бас соёрхон батлагдаагүй байгаа. Тийм учраас энэ дээр энэ процесс болоод ирэх дээр Алтайгаасаа эхлэх үү, Улиастайгаас эхлэх үү гэдэг бас ахиад яригдах байх гэж бодож байна.

Үлдэгдэл хөрөнгийн хувьд энэ бол АХБ-ны 3 дахь шатын төслөөр явагдах гээд яригдаж байгаа асуудал. Үлдэгдлийг нь бид нар 4 дэх шатын төсөл дээр яригдсан. Одоогоор 4 дэх шатын төсөл бас яг эцэслэж албажаагүй явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хүрэлбаатар гишүүн. Хүрэлбаатар сайдад микрофон өгье. Асуулт асууя.

Ч.Хүрэлбаатар: Үгүй ээ, яах вэ. Би энэ дээр энэ үг хэлэхдээ зүгээр Пүрэвдорж гишүүний хэлсэн үгэн дээр л жоохон юм яримаар байгаа юм. Та санал гаргаж байгаа бол саналаа л ярь л даа. Хажууд нь Засгийн газар руу дайрдаг нь ямар учиртай юм, дайрч дандаа л нэг улс төр хийж байх юм, явуургүй. Тэгээд яах юм. Ховд аймгийн бүх сумуудаас гуравхан сум холбогдоогүй авто замаар холбогдоогүй түүний үлдсэн нэг сумыг нь Зэрэг сумыг нь холбоё гэдэг саналаа та гаргаад л ярь л даа. Гэтэл хажуу талд чинь Баярсайхан гишүүн аймгийг холбох тухай асуудал ярьж байхад та зүгээр л энэ хүн чинь ном ёсоор нь ярьчихаж байна шүү дээ.

Хажууд нь Засгийн газар руу дайрдаг нь ямар учиртай юм. Тэгээд Их Хурлын дээр гарчихсан Засгийн газар гэж хаана байгаа юм. Жоохон хэдүүлээ улс төр хийж болно, гэхдээ аймгийнхаа нэг сум руу зам тавиулахын тулд бүхэл бүтэн Засгийн газрыг доромжилж болохгүй шүү дээ. Үүнийг л хэлэх гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалгаагүй нэгдсэн хуралд нээлттэй үлдээсэн саналуудын санал хураалтыг явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасныг үндэслэн хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар чиглэл өгсөн.

1.Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан, Тогтоолын төслийн 2-р хавсралтын 4.3.1.24 дэх дэд заалтын Төсөл, арга хэмжээнд “Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих” гэж нэмэх, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “50” гэж, Санхүүжилтэд “75.17 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Гадаадын зээл” гэж, Хариуцагч байгууллагад “Зам, тээврийн хөгжлийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ. Санал хураалт.

Санал 70 хувиар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад “Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд олон ба гурван талт зөвшилцөл, түншилэл, хяналтын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэн хэвшүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар. Санал хураалт.

Санал 70 хувиар дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 4.3.1 дэх заалтын Төсөл, арга хэмжээнд “Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг Цэцэг сумыг холбох авто зам барих “32.4 км” гэж, Шалгуур үзүүлэлтэд “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, Хэмжих нэгжид “Хувь” гэж, Суурь түвшинд “-” гэж, Зорилтот түвшин “Ажлын гүйцэтгэл” гэж, Санхүүжилтэд “29 тэрбум төгрөг” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрт “Улсын төсөв” гэж, Хариуцагч байгууллагад “ЗТХЯ” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Санал хураалт.

Санал 80 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын Монгол Улсын 2024 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн ерөнхий зүйлийн “үндэслэнн боловсрууллаа.” “үндэслэлээ” гэж, “төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа” гэснийг “төлөвлөгөө нь” гэж, “үндэслэн” гэснийг “үндэслэсэн бөгөөд” гэж “тодорхойллоо” гэснийг “тодорхойлно” гэж, мөн тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “Бодлогын үндэслэл” хэсгийн Алсын Хараа /АХ/, 2.3.2.16 дахь дэд заалтын “3.2.14” гэснийг “6.4.22” гэж, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /МУХТЖҮЧ/-ийн 2.1.3 дахь заалтын

“4.2.2” гэснийг “4.4.3” гэж, мөн 3.1.4.1-3.1.4.5, 3.1.4.7, 3.1.4.8, 3.1.5.1 дэх дэд заалтын “2.1.9” гэснийг “2.1.12” гэж, мөн 4.2.1.1 дэх дэд заалтын “3.6.4” гэснийг “4.2.10” гэж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/-ийн 6.2.3 дахь заалтын “4.3.9” гэснийг “3.5.7” гэж, мөн тогтоолын төслийн 3 дугаар хавсралтын 2.5 дахь заалтын “бүсүүд” гэснийг “бүсүүдийн” гэж, 3.2 дахь заалтын Хэмжих нэгжийн “Хүн” гэснийг “Хувь” гэж, 3.3.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлтийн “хамралт” гэснийг “хамрагдалт” гэж, 3.3.3 дахь дэд заалтын Зорилтот үр дүнгийн “нэмэгдэнэ” гэснийг “нэмэгдүүлнэ” гэж, Шалгуур үзүүлэлтийн “насныхны” гэснийг “насны” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Дээрх зарчмын зөрөөтэй саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж, өөрчлөөрэй гэж ажлын хэсэгт чиглэл өгч байна.

Ингээд тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Баярсайхан гишүүн түрүүний санал гаргасан шүү дээ. Хариултыг бол Бямбацогт гишүүн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд Бямбацогт хариулсан. Ер нь бол 140 хэд гэж байгаа билээ? километр замыг бол 198 км зам бол ерөнхийдөө Зам тээврийн хөгжлийн бодлогод бол тусчихсан байгаа, тийм үү. Нэг тусчихсан байгаа бол эхлүүлээд явчихна. Зүгээр энэ дээр бол дэгийн хуулийг би нэг танилцуулаадахъя.

Дэгийн тухай хуулийн 42.2.3 нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээс санал хурааж, дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн. Нэг.

Нөгөөдөх нь 42.3 энэ хуулийн 42.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно гэж. Тийм болохоор Дэгийн тухай хуулиараа бол нөгөө 2 дахь хэлэлцүүлэг дээр дахин санал гаргах боломж бололцоо байхгүй байгаад байна. Тэгэхээр саяын хэлснээр үг хэлэх горим байхгүй л байна л даа.

Тэгэхээр ерөнхийдөө бол Зам, тээврийн хөгжлийн сайд өөрөө харцуулчихсан юм чинь энэ бодлого дотор ороод ингээд явчих байх л гэж бодож байгаа. Яг дэгийнхээ хувьд бол өнөөдөр санал гаргах боломжгүй болчихоод байна шүү дээ. Тийм. Сарангэрэл гишүүнийх бас санал гаргасан юм байна. Тийм. Б.Баярсайхан гишүүн, Б.Баярсайхан гишүүн 2 санал гаргасан юм байна. Гаргах гээд саналын томъёолол өгсөн байна. Д.Сарангэрэл гишүүн 1 санал гаргахаар саналын томъёолол өгсөн. Энэ дэгийнхээ тухай хуулийн хувьд хэлэлцэх, хураалгах бололцоогүй болчихоод байна.

Үг хэлэх дэг байхгүй л байна даа. Чуулган дээр үг хэлчих тийм.

Ингээд тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Ингээд “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга харцуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр гишүүн танилцуулна.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа. Хуралдаанд оролцсон гишүүдэд баярлалаа.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

12:12

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА